



### АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2022 оны 03 сарын 15 өдөр

№ WHA 22/02

Улаанбаатар хот

Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г НЭГ ТАЛААС 6289088 тоот регистрийн дугаартай, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 5 дугаар хороо, Голомт хотхоны А байрны 60 тоот хаягт байрладаг “ДАБЛЮ ЭЙЧ ЭЙ” ХХК (цаашид “Гүйцэтгэгч” гэх)-ийг төлөөлж Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал Т.Азжаргал, НӨГӨӨ ТАЛААС 6021646 тоот регистрийн дугаартай, УБ, БЗД-ийн 8-р хороо УС15-1-1 хаягт байрлах “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” ТӨХК(цаашид “Захиалагч” гэх)-ийг төлөөлж Хяналтын хэлтсийн дарга П.Зоригоо нар (цаашид тус тусад нь “Тал”, хамтад нь “Талууд” гэх) Иргэний хуулийн 343-358 дүгээр зүйлийг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцсоноор энэхүү гэрээг байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээгээр захиалагчийн УБ, БЗД-ийн 8-р хороо УС15-1-1 хаягт байрлах дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн нийт 47 ажлын байранд буй 156 ажилтныг хамруулан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 28.1.5-д заасан Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ, Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийх ажлыг Гүйцэтгэгч тал хэрэгжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2 Захиалагч нь түүнд тохирсон хөлсийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.
- 1.3 Гүйцэтгэгч тал нь хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний хүрээнд хийгдэх лабораторийн шинжилгээг MNS ISO/IEC 17025 стандартаар Итгэмжлэгдсэн лабораторийг түшиглэн хийнэ.
- 1.4 Энэхүү Гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг Иргэний хууль, Өрсөлдөөний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартад заасны дагуу зохицуулна.
- 1.5 Талууд Гэрээнд заасан үүргийг зохих ёсоор гүйцэтгэж, гэрээт ажлыг эхлүүлснээс хойш нэг сарын хугацаанд гэрээт ажлыг хийж, тайланг хүлээлгэж өгсөнөөр гэрээний харилцаа дуусгавар болно.

### ХОЁР. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 2.1. Энэхүү Гэрээний нийт үнэ 13.200.000 (Арван гурван сая хоёр зуун мянган) төгрөг байна. Уг үнийн дүнд нэмүү өртгийн албан татвар (НӨАТ) орсон болно.
- 2.2. Захиалагч тус гэрээг батлагдсанаас хойш гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн ажил эхлэхийн өмнө гэрээний нийт үнийн дүнгийн 30% (3.960.000 буюу гурван сая есөн зуун жаран мянга)-ийг Гүйцэтгэгч байгууллагын гэрээнд заасан дансанд шилжүүлнэ.

Гэрээний дугаар	Огноо	Талууд үзэглэх		Хуудасны тоо
		Захиалагч:	Гүйцэтгэгч:	Хуудас 1 / 6

- 2.3. Талууд гэрээт ажлын үлдэгдэл 70% (9.240.000 буюу Есөн сая хоёр зуун дөчин мянга)-ийг үнэлгээний тайлангийн танилцуулах уулзалт хийсний дараа төлөхөөр тохиролцсон болно.
- 2.4. Гүйцэтгэгч нь тайлангийн хурал хийсний дараа тайлангийн хувийг Захиалагчид хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэж өгнө.
- 2.5. Захиалагч нь төлбөрийг Гүйцэтгэгчийн ХААН банкны 5009910129 тоот дансанд шилжүүлнэ.
- 2.6. Захиалагч нь төлбөрийг Монгол Улсын Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуульд зааснаар “Төгрөг”-өөр гүйцэтгэнэ.
- 2.7. Төлбөр хийх өдөр нь амралтын өдөр, нийтээр амрах, баяр ёслолын өдөртэй давхцсан тохиолдолд дараагийн эхний ажлын өдөр төлбөрийг төлнө.

### ГУРАВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР, ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 3.1. Ажил гүйцэтгэх газар нь УБ, БЗД-ийн 8-р хороо УС15-1-1 хаягт байрлах дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн нийт 47 ажлын байранд буй 156 ажилтныг хамруулан хийнэ.
- 3.2. Ажил гүйцэтгэх гэрээний хугацаа нь гэрээний хүрээнд ажлын төлөвлөгөөг талууд зөвшилцөж батлах ба гэрээт ажлыг эхлүүлсэнээс хойш 30 хоног байна.

### ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. Гүйцэтгэгч нь Хавсралт 1-д заасан Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ болон хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хэрэгжүүлэхдээ Захиалагчаас гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах;
- 4.2. Ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан сонгосон ажлын байрнуудад нэвтрэх, аюулгүй орчинд ажиллах боломж бүрдүүлэхийг захиалагч талаас шаардах, энэ шаардлагыг хангаагүй гэж үзвэл шаардлагыг биелүүлтэл ажлыг түр зогсоох
- 4.3. Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийхтэй холбоотой шаардагдах мэдээлэл, баримт бичгийг Захиалагч талаас гаргуулах;
- 4.4. Гэрээг байгуулсанаас хойш ажлын үр дүнг хүлээлгэн өгөх хугацаанд гэрээний үнэд өөрчлөлт оруулахгүй байх;
- 4.5. Гүйцэтгэгч нь үнэлгээний үр дүнд үндэслэн холбогдох хуулийн зохицуулалтын хүрээнд гэрээний үр дүн болон дүгнэлтийг бие даан гаргах эрхтэй
- 4.6. Гүйцэтгэгч нь Захиалагчийн ажлын талбайд хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны журмыг дагаж мөрдөж биелүүлэх;
- 4.7. Гүйцэтгэгч нь Захиалагчийн ХАБЭА-н зөвшөөрлийн хуудсыг бөглөн холбогдох эрх бүхий албан тушаалтны зөвшөөрлийн үндсэн дээр ажлыг эхэлнэ.
- 4.8. Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, Гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон бол нэн даруй захиалагчид мэдэгдэх.
- 4.9. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний тайланг Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 тушаал (Ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам)-ын дагуу батлагдсан форматаар 2 хувь, Хөдөлмөрийн эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний тайланг 2 хувь үйлдэж нэг хувийг захиалагчид, нэг хувийг гүйцэтгэгч байгууллагын архивт үлдээнэ. Тайлан тус бүрээс нэг хувийг Захиалагчид хүлээлгэн өгөхдөө ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан болон удирдах ажилтнуудад танилцуулах уулзалт зохион байгуулж, хэвлэмэл хэлбэрээр хүлээлгэн өгнө.
- 4.10. Иргэний хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

### ТАВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. Гэрээнд заасан ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэхэд шаардагдах гэрээний хүрээнд батлагдсан санхүүжилтийг хугацаанд нь шилжүүлэх, хүний нөөц, удирдлагаар хангах
- 5.2. Гүйцэтгэгч байгууллагын ажилтнуудыг гэрээнд заасан ажлыг хугацаанд нь аюулгүй нөхцөлд хийж гүйцэтгэх болон бие даан шийдвэр гаргах боломж нөхцөлөөр хангах
- 5.3. Гүйцэтгэгчээс гэрээнд заасан үүргээ чанартай биелүүлэхийг шаардах;

Гэрээний дугаар	Огноо	Талууд үзэглэх		Хуудасны тоо
		Захиалагч:	Гүйцэтгэгч:	Хуудас 2 / 6

- 5.4. Гүйцэтгэгчээс гэрээнд заасан хугацаанд холбогдох хууль, дүрэм, журам, зааврын дагуу холбогдох хэмжилт шинжилгээг хийж ажлын үр дүнг эцсийн байдлаар баримтжуулсан тайланг хүлээлгэн өгөхийг шаардах;
- 5.5. Ажил гүйцэтгэхтэй холбогдуулан Гүйцэтгэгчийн хүсэлт гаргасан мэдээ мэдээлэл, баримтыг цаг тухайд нь гаргаж өгөх;
- 5.6. Гүйцэтгэгчээс ажлын үйл явцтай холбоотой мэдээллийг тухай бүрт авах;
- 5.7. Ажлын үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа хоцроосон болон доголдол илэрсэн тохиолдолд хүлээн авахаас татгалзаж доголдлыг арилгуулах, учирсан хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага гаргах эрхтэй.
- 5.8. Захиалагч нь Гэрээнд заасан хугацаанд ажлын үр дүнг дагалдах бичиг баримт мэдээллийн хамт заасан газарт хүлээн авах;
- 5.9. Иргэний хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

## ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

- 6.1. Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг буруутай Тал бүрэн хариуцаж төлнө.
- 6.2. Гэрээний аль нэг тал нь дараах нөхцөл бий болсон тохиолдолд гэрээг цуцалж болно:  
 6.2.1. Ямар нэгэн үр дүн гарахгүй болох нь илт бол.  
 6.2.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол.
- 6.3. Талууд Гэрээний 6.2-т заасан үндэслэлээр Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч нь гэрээг цуцалснаас хойш ажлын 5 хоногт багтаан төлөгдсөн төлбөрийг Захиалагчийн дансанд 100% буцаан шилжүүлнэ.
- 6.4. Ажлын үр дүнг Захиалагчийн өмчлөлд шилжүүлсэн үеэс эхлэн ажлын үр дүнтэй холбоотой эрсдэл Захиалагчид шилжинэ.
- 6.5. Захиалагч гэрээнд заасан санхүүжилтийг хугацаанд нь шилжүүлээгүй эсвэл гэрээнд заагаагүй шалтгаанаар ажил эхэлсэний дараа эсвэл ажлын явцад цуцлахаар бол Гүйцэтгэгч талаас гаргасан зардлыг Захиалагч талаас гаргаж хохиролгүй болгоно.
- 6.6. Гүйцэтгэгч нь гэрээнд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй бол гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнтэй тэнцэх торгуулийг Захиалагчид төлнө.
- 6.7. Гэрээнд тусгагдаагүй нэмэлт ажил гарсан тохиолдолд нэмэлт төсвөөр харилцан тохиролцож, бичгээр үйлдэн шийдвэрлэнэ. *(Гэрээний хүрээнд хамаарах ажил болон батлагдсан үнийн дүнгийн задаргааны жагсаалтыг хавсралт 1 болон хавсралт 2-д оруулав)*
- 6.8. Талууд энэ гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг Талын зөвшөөрөлгүйгээр буслад шилжүүлэх болон энэхүү гэрээг дангаар цуцлахыг хориглоно.

## ДОЛОО. НУУЦЛАЛ

- 7.1. Талууд энэ гэрээний дагуу хүлээн авсан мэдээ, мэдээлэл, баримт бичгийн нууцлалыг чанд нууцалж хадгална.
- 7.2. Талуудын хооронд шилжүүлэн өгсөн нууцын чанартай мэдээлэл, баримт бичигтэй Гүйцэтгэгч, Захиалагчийн энэхүү гэрээний дагуу хийж байгаа ажил, үйлчилгээтэй шууд холбоо бүхий хүмүүс танилцана.
- 7.3. Талууд гэрээ байгуулсантай холбогдон шууд болон шууд бусаар мэдсэн, олж авсан, Талуудтай холбоотой бизнесийн нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээлэл, баримт (үүнд: бүх төрлийн гэрээ, хэлцэл, үнийн санал гэх мэт)-ийг нөгөө Талын зөвшөөрөлгүйгээр өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд эсхүл гэрээний нөгөө талын эсрэг ашиглахгүй, аливаа гуравдагч этгээдэд амаар буюу бичгээр задруулахгүй, дамжуулахгүй байх үүргийг хүлээнэ.

## НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

**8.1. Хүчин төгөлдөр болох.** Энэхүү Гэрээнд Талууд гарын үсэг зурснаар Гэрээ хүчин төгөлдөр болно.

**8.2. Хэрэглэх хууль.** Энэхүү Гэрээний агуулга, тайлбар нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байна. Талууд энэхүү Гэрээтэй холбоотой үүссэн аливаа маргааныг харилцан

Гэрээний дугаар	Огноо	Талууд үзэглэх		Хуудасны тоо
		Захиалагч:	Гүйцэтгэгч:	Хуудас 3 / 6

тохиролцоо замаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд хэрэв тохиролцоонд хүрч чалаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

**8.3. Давагдашгүй хүчин зүйл.** Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас Талуудын аль нэг нь Гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол энэ тухай нөгөө Талдаа нэн даруй мэдэгдэнэ.

**8.4. Хавсралт.** Хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

**8.5. Нэмэлт, өөрчлөлт.** Энэхүү Гэрээнд болон Хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болсонд тооцно.

**8.6. Гэрээний нэгдмэл байдал.** Энэхүү Гэрээ нь Талуудын хооронд амаар болон бичгээр үйлдэгдсэн бүхий л урьдчилсан тохиролцоо, мэдэгдэл, баталгаа болон хэлэлцээрийг орлох бөгөөд Гэрээ нь бүхэлдээ Гэрээнд заасан харилцааг зохицуулсан үндсэн баримт бичиг болно.

**8.7. Гэрээний хувь.** Энэхүү Гэрээг хоёр хувь үйлдэх бөгөөд Талууд гарын үсэг зурж, нөгөө Талдаа хүргүүлснээр баталгаажуулсанд тооцно.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  
П.ЗОРИГОО



ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Г.ЭРДЭНЭБИЛЭГ



СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖИЛ  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Ө.УДВАЛ



#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ДАБЛЮ ЭЙЧ ЭЙ ХХК-ИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ДЭД  
ЗАХИРАЛ Т.АЗЖАРГАЛ



Огноо: / \_\_\_\_\_ /

Огноо: / 2022-3-15 /

Гэрээний дугаар	Огноо	Талууд үзэглэх		Хуудасны тоо
		Захиалагч:	Гүйцэтгэгч:	Хуудас 4 / 6